

2020 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ЗӨВ САНХҮҮЖИЛТ

## АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	03
Оны онцлох үйл явдлууд	05
Зээлийн үйл ажиллагаа	06
Шинэ бүтээгдэхүүн	07
Нийгмийн хариуцлага	09
Эрсдэлийн удирдлага	10
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	11
Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан	12
Хувьцааны мэдээлэл	13

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



*"Ковид-19-н үед эрсдэлийн бодлогоо шинэчилж, санхүүгийн бүх үзүүлэлтүүдээр өсөлттэй, активын чанараа сайжруулан ажиллаж байна"*

*"Үр ашиггүй зардлыг бууруулах, процессыг автоматжуулах тал руу түлхүү анхаарч байна"*

Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, түншүүд та бүхэндээ 2020 оны эхний хагас жилийн Санхүү, үйл ажиллагааны тайлангаа хүргэж байгаадаа баяртай байна.

Хэдий Корона вирусын халдвар дэлхий нийтийг түгшээж, бодит эдийн засагт сөргөөр нөлөөлж байгаа ч бид энэ оны эхний хагас жилийн санхүүгийн тоон үзүүлэлтүүдээ өсгөн актив хөрөнгийн чанараа сайжруулж, ажлын байрыг хадгалан ажиллаж чадлаа.

Халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж эхлэхэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бид 2 дугаар сараас эхлэн эрсдэлийн бодлогоо чангаруулж, зээлийн чанарт онцгой анхаарч, анхаарал татсан зээлүүд дээр цаг алдалгүй арга хэмжээ авч эхэлсэн. Мөн үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийг нарийн тооцсон, чанартай, тогтвортой үйл ажиллагааг чухалчлан, энэ оны бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө зохих өөрчлөлтүүдийг оруулж, шинэчилсэн төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Ингэхдээ аль болох үр ашиггүй зардлыг бууруулах, процессыг автоматжуулах тал руу түлхүү анхаарч байна.

**ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН 2020**

2020 оны эхний хагас жилд бид 4 салбар шинээр байгуулснаар Улаанбаатар хотод 12 салбар, Эрдэнэт хотод 1 салбар, Киргиз улсад 1 салбар, нийт 14 салбартай боллоо.

Байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг өмнөх оны эцэстэй харьцуулахад нийт хөрөнгийн дүн 19%-аар өсч 97.4 тэрбум төгрөг, зээлийн багц 20%-иар өсч 72.8 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 15%-аар өсч 46.5 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 61%-аар өсч 13.3 тэрбум төгрөг, цэвэр ашиг 52%-аар өсч 6.1 тэрбум төгрөгт хүрсэн бол чанаргүй зээлийн хувь 1.41 функтаар буурсан сайн үзүүлэлттэй гарлаа.

Нийгмийн хариуцлагын хүрээнд бид халдварт өвчний эсрэг үйлвэрлэл, үйлчилгээ явуулж буй үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж тэдэнд зориулсан хүүгүй зээл олгосныгоо дурдахад таатай байна. Мөн Ковид-с шалтгаалан бизнесийн үйл ажиллагаа нь саатсан, зогссон олон харилцагч нартайгаа уулзаж, он гарснаас хойш 596 харилцагчийн 18.3 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна. Бид энэ хүнд цаг үеийг аль болох харилцагчдаа таатай нөхцлөөр дэмжиж, хамтдаа даван туулах уян хатан бодлого барьж ажиллаж байна. Манай ББСБ-ын нийт зээлийн багцын 60-с дээш хувь нь иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч нарт олгосон бага дүнтэй зээл байдаг ба нэг зээлдэгчид ногдох дундаж үлдэгдэл 6.0 сая төгрөг, төвлөрлийн эрсдэл бага байдгийн давуу тал гарч байна.

2020 онд бид Санхүүгийн Зохицуулах Хорооноос 10 тэрбум төгрөгийн хаалттай бондыг гаргах зөвшөөрлийг авч, амжилттай хэрэгжүүлж байгаа ба андеррайтар компаниар үнэт цаасны зах зээлд Монголдоо тэргүүлэгч ТДБ Капитал ХХК ажиллаж байна.

Мөн процессыг автоматжуулах, хүний оролцоог багасгах бодлогын хүрээнд зээл, бусад үйлчилгээг богино хугацаанд шийдвэрлэх Киоск машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгааг дуулгахад таатай байна.

Киоск машин нь харилцагчийг хурууны хээгээр нь таньснаар, автомат зээлийн скорингийн систем ажиллаж зээлийг маш богино хугацаанд шийдвэрлэнэ. Ингэснээр харилцагчдад түргэн шуурхай санхүү, зээлийн үйлчилгээг авах, хүн хоорондын шууд харилцааг багасгаж халдварт өвчний бодит эрсдэлийг бууруулах, иргэдийг технологид суурилсан шинэ үеийн шинэлэг үйлчилгээг ашиглахад сургах зэрэг олон давуу талтай юм.

Бид орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулах, орон нутагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар харилцан ашигтай хамтын ажиллагаа бий болгох зорилгоор Инвескор Алианс хөтөлбөрийг ирэх 8 дугаар сард эхлүүлэхэд бэлэн болоод байна. Тус хөтөлбөрт аймаг бүрээс тухайн орон нутгийн ББСБ-уудыг сонгон шалгаруулж, шаардлагад нийцсэн байгууллагуудыг нэгтгэн Инвескорын үйл ажиллагааны процесс, системд суурилсан ололтуудыг үйл ажиллагаандаа тусгах, улмаар орон нутагтаа санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, тухайн аймгийн ард иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй, хялбар байдлаар хүлээн авах боломжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээ, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх зэрэг маш олон давуу талуудыг бий болгох юм.

Мөн санхүүгийн секторт үйл ажиллагаа явуулж буй бусад банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол улсын санхүүгийн болон түүнийг дагалдах секторуудын хөгжилд технологи дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлүүдээр дамжуулан тодорхой хувь нэмэр оруулахыг чухалчлан ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

“Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Д.Баясгалан

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- ✓ 600 гаруй харилцагчийн зээлийн гэрээний нөхцөлд үнэ төлбөргүй өөрчлөлт оруулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүллээ.
- ✓ Ковид-19 той холбоотойгоор эрүүл мэндийн салбарын үндэсний үйлдвэрлэгчдэд хүүгүй зээл олголоо.
- ✓ Харилцагчдын хэрэгцээ шаардлагыг илүү сайн хангах зорилгоор "Шуурхай зээл"-ийн төвүүдийг байгуулж, зээлийн судалгаа шийдвэрийг 30 минутын дотор шийдвэрлэж байна.
- ✓ Үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор эхний хагас жилд шинээр 4 салбар нээв.
- ✓ Монгол Улсын Хөрөнгийн биржийн хувьцаат компаниудын 2 дугаар ангилалруу шилжив.
- ✓ Хаалттай хүрээнд 10.0 тэрбум төгрөгийн бонд амжилттай гаргалаа.
- ✓ Монгол Улсын Хөрөнгийн биржийн ТОП 20 ААН-д багтсан.
- ✓ Pocket аппликейшн V2. гаргаж, чат, купон, QR төлбөр тооцоо зэрэг шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэв.
- ✓ Бусад ББСБ-уудтай нэгдэж Ковид-19-н эсрэг хандивын аяны хүрээнд УОК-д 100 сая төгрөгийн хандив өглөө.
- ✓ Киргиз улсын төв банканд цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргав.
- ✓ 2020 оны "Хувьцаа эзэмшигчдийн хурал"-ыг цахим орчинд, дуу хоолой таних технологи ашиглан амжилттай зохион байгуулав.

## ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2020 оны эхний хагас жилийн байдлаар

/төгрөг/


НИЙТ ХӨРӨНГӨ	ЗЭЭЛИЙН БАГЦ	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	НИЙТ ОРЛОГО	ЦЭВЭР АШИГ
97.4 тэрбум	72.8 тэрбум	46.5 тэрбум	13.3 тэрбум	6.1 тэрбум
↑ 50%	↑ 38%	↑ 30%	↑ 61%	↑ 52%

/сая төгрөг/


	2019 II	2019 IV	2020 II	Өсөлт/Бууралт
Харилцагчийн тоо	4,712	10,690	47,763	↑ 914%
Зээлийн олголтын дүн /сая MNT/	128,262	166,880	214,599	↑ 67%
Чанаргүй зээл /хувиар/	4.45%	2.60%	2.86%	↓ 1.59%

/Өмнөх оны мөн үетэй харьцуулахад/

### НИЙТ ХӨРӨНГӨ САЯ ТӨГРӨГӨӨР



### ОРЛОГО, АШИГ САЯ ТӨГРӨГӨӨР




2020 оны 2 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрийн хөрөнгө 30%, нийт хөрөнгийн дүн 50%, нийт орлого 61%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН:



### ШУУРХАЙ ЗЭЭЛ

Автомашин болон орон сууц барьцаалсан 50 сая төгрөг хүртэлх дүнтэй шуурхай зээлийг хамгийн боломжит нөхцөлөөр санал болгож, олгосоор байна.



### ХААЛТТАЙ БОНД

Инвескор ББСБ ХК /MSE: INV/ 10.0 тэрбум төгрөгийн жилийн 18% хүртэлх өгөөжтэй үнэт цаас гаргав. Хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгосон 10,000 ширхэг бондын нэг бүрийн үнэ нь 1,000,000 төгрөг юм.





### VIP ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчиддаа хөрөнгөө хэрхэн үр ашигтай удирдах талаар үнэ төлбөргүй, VIP зөвлөх үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь харилцагчдын хүсэлд нийцсэн, хамгийн эрэлт ихтэй үйлчилгээ болоод байна.



### ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Харилцагчдад зах зээлийн дунджаас харьцангуй өндөр өгөөжийг санал болгодгоороо онцлог бүтээгдэхүүн юм. Харилцагч тус компанид итгэл үзүүлэн төгрөг жилийн 18%, валютын 8% хүртэл өгөөжийг авдаг.



### ЧАТ, ДУГТУЙ

Pocket Chat функц нь Хэрэглэгчид хоорондоо чаталж болохоос гадна, чат дотроо Шилжүүлэг хийх боломжийг бүрдүүлсэн.

Мөн **Pocket Chat**-ийн Хэрэглэгчид хэн нэгэн рүү Дугтуй илгээх боломжтой болсон ба тэмдэглэлт баярын өдрүүдээр хэрэглэгчдийн хамгийн их хэрэглэдэг цэс болсон байна.



### КУПОН

**Pocket Coupon** үйлчилгээ нь хамтрагч байгууллагууддаа бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, борлуулалтаа нэмэгдүүлэх боломжийг олгохын зэрэгцээ Хэрэглэгчдэд тухайн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хямд, илүү урамшуулалтай хүргэх боломжтой болсон.



### QR ТӨЛБӨР ТООЦОО


Pocket-ийн **QR** кодуудыг үйлчилгээний газруудад байрлуулан Pocket-ийн хэрэглэгчид бүх төрлийн үйлчилгээний газруудаас Pocket-оороо худалдан авалт хийхэд ямар нэгэн шимтгэлгүй үйлчлүүлэх боломжтой боллоо.



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

COVID-19-тай холбоотой бизнесийн үйл ажиллагаа нь хүндэрсэн харилцагч нарынхаа зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчилж, үндсэн зээлийн төлөлтийг хойшлуулж, зээлийн гэрээний нөхцөлд шимтгэлгүйгээр өөрчлөлт оруулж ажилласан. 18.27 тэрбум төгрөгийн 596 зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан байна.



### УЛААНБААТАР ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ - САНХҮҮЖИЛТ

Инвескор санхүүгийн байгууллага нь Монгол улсын эрүүл мэндийн салбарт хяналт шинжилгээний үйлчилгээ болон хэрэглэгчдэд хандсан ухаалаг шийдлээрээ анхдагч болон ажиллаж байгаа Ногоон титэм ХХК-д 15 сая төгрөгийн хүүгүй зээлийг нийгмийн хариуцлагын сангаасаа олголоо. "Гипон" уусмал нь хүхэрт ус төрөгчийн үнэрийг 99.99% арилгаж, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийн таагүй үнэрийг дарах юм.



### КОВИД-19 - "МОНГОЛ МАСК ЭРДЭНЭТ"

Дэлхий дахинд тархаад байгаа "Ковид-19"-тэй бодит аюул буурахгүй байгаа энэ үед дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "Монгол Маск Эрдэнэт" ХХК-д 30 сая төгрөгийн хүүгүй зээлийг олголоо.



### КОВИД-19 - "УОК"

Мөн "Ковид-19"-тэй холбогдуулан Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос зохион байгуулсан хандивын аянд нэгдэж "Улсын Онцгой Комисс"-т 100 сая төгрөг хандивлав.



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА:

2020 оны 2 дугаар улиралд Инвескор ББСБ ХК эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж, хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлж, холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн бодлого, журмуудаа шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж эхэллээ.

Энэхүү тогтолцооны хүрээнд ТУЗ-ийн Аудитын хороонд сар бүр эрсдэлийн тайлан хянуулж байна.

ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан бөгөөд тэдгээр нь дараах чиг үүрэг үүрэгтэй байна.

- ✓ Хамгаалалтын нэгдүгээр бүс буюу бизнесийн нэгжүүд болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд нь эрсдэлийг хариуцах эзэн байх бөгөөд эрсдэлийг үнэлэх, хянах, бууруулах чиг үүрэгтэй байна.
- ✓ Хамгаалалтын хоёрдугаар бүс буюу Хууль, Эрсдэлийн удирдлагын газар нь эрсдэлийг хяналтыг хэрэгжүүлж ажиллах бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, холбогдох бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоох, хянах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байхаас гадна хамгаалалтын нэгдүгээр бүсийн үйл ажиллагаанд мониторинг хийж, заавар зөвлөмжөөр хангаж ажилладаг.
- ✓ Хамгаалалтын гуравдугаар бүс нь Дотоод аудитын газар байх бөгөөд Хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хараат бус үнэлэлт өгч ТУЗ-д баталгаажуулалт өгч ажиллах чиг үүрэгтэй.

ББСБ нь зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого болон холбогдох үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлуулж байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь эрсдэлд суурилсан аргачлалаар харилцагчийг үнэлэх, зээл олгох шалгуурыг эрсдэлд суурилсан байдлаар тогтоох, харилцагчийг зээлийн эрсдэлд орохоос хамгаалах зэрэг хариуцлагатай, зөв зээлийн үйл ажиллагааг харилцагчид хүргэх давуу талыг бий болгож байна. ББСБ нь зээлийн болон зээлийн төвлөрлийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тогтоон түүнийг ханган ажиллаж байна.

ББСБ-ын нэгж бүр өөрийн хариуцдаг үйл ажиллагааны процессыг тодорхойлж, тухайн процесст оролцогчдийн чиг үүргийг тодорхойлон байгууллагын үйл ажиллагааны эрсдэлээс амжилттай хамгаалан ажиллаж байна.

ББСБ нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо амжилттай суурилуулж, холбогдох бодлого журмуудаа шинэчилсэнтэй зэрэгцэн Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон холбоотой компаниудын бүхий л ажилтнуудыг хамруулсан "Эрсдэлийн соёл"-ыг түгээх шат дараалсан сургалтуудыг амжилттай зохион байгуулж ажилтан бүр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг, ажилтан бүр эрсдэлийн менежер байх соёлыг түгээн ажиллаж байна.

ББСБ нь харилцагчиддаа шинэ технологид суурилсан хурдан шуурхай, сонирхол татсан өрсөлдөхүйц, хэрэглэгч төвтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож ажилладаг бөгөөд Мэдээлэл технологи, Мэдээллийн аюулгүй байдал, Цахим аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулан олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн ажиллаж байна.

## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

2020 оны эхний хагас жилийн байдлаар

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	Байвал зохих	Тайлангаар
<b>Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт</b>		
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	<b>46.4%</b>
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	<b>46.4%</b>
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	<b>47.7%</b>
<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>		
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	<b>13.4%</b>
<b>АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>		
Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	<b>8.5%</b>
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	25%-аас хэтрэхгүй	<b>0.6%</b>
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	<b>0.1%</b>
Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	<b>8.3%</b>
<b>ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ</b>		
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	<b>5.8%</b>
<b>БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>		
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-аас хэтрэхгүй	<b>53.3%</b>
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	<b>6.0%</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>		
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	<b>5.3%</b>
<b>ӨГӨӨЖ</b>		
Хөрөнгө /Актив/-ийн өгөөж		<b>7.5%</b>
Өөрийн хөрөнгийн өгөөж		<b>14.9%</b>

**"ИНВЕСКОР ББСБ" ХК НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН:**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН		/мянган төгрөг/		
	2020 Q2	2019 Q4	2019 Q2	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,285,988	5,146,145	3,019,268	
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3,867,405	3,599,750	4,006,180	
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	72,811,761	60,645,316	52,923,514	
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө - цэвэр	-	1,055,576	388,669	
Хүүгийн авлага	3,628,616	1,662,559	1,819,980	
Бусад хөрөнгө	4,372,925	2,309,789	1,922,087	
Үндсэн ба биет бус хөрөнгө	7,447,013	7,483,027	985,210	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>97,413,708</b>	<b>81,902,162</b>	<b>65,064,908</b>	
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	26,081,056	19,933,800	12,887,975	
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	16,348,060	14,515,976	11,863,571	
Бусад санхүүгийн өр төлбөр	8,491,306	7,063,692	4,660,058	
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>50,920,422</b>	<b>41,513,468</b>	<b>29,411,604</b>	
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>				
Хувьцаат капитал	16,282,237	16,282,237	16,282,237	
Нэмж төлөгдсөн капитал	15,377,738	15,377,738	15,298,408	
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)	14,833,311	8,728,719	4,072,658	
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>	<b>46,493,286</b>	<b>40,388,694</b>	<b>35,653,303</b>	
<b>Нийт пассив ба өөрийн хөрөнгө</b>	<b>97,413,708</b>	<b>81,902,162</b>	<b>65,064,908</b>	

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН		/мянган төгрөг/		
	2020 Q2	2019 Q4	2019 Q2	
Хүү болон түүнтэй адилтгах орлого	11,678,636	19,362,985	7,765,954	
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(2,432,952)	(4,192,760)	(1,027,190)	
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>9,245,684</b>	<b>15,170,225</b>	<b>6,738,764</b>	
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,487,307	2,600,157	285,906	
Гадаад валютын арилжаа болон ханшийн тэгшитгэлийн орлого/зардал	139,192	159,154	221,803	
<b>Хүүгийн бус орлого</b>	<b>10,872,184</b>	<b>17,929,536</b>	<b>7,246,472</b>	
Ажиллагсадтай холбогдолтой зардал	(1,347,521)	(3,000,568)	(543,764)	
Үйл ажиллагааны бусад зардал	(2,508,298)	(3,664,400)	(1,423,802)	
<b>Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал</b>	<b>7,016,365</b>	<b>11,264,568</b>	<b>5,278,907</b>	
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(294,590)	(56,963)	(532,936)	
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>6,721,775</b>	<b>11,207,605</b>	<b>4,745,970</b>	
Орлогын албан татвар	(617,183)	(2,548,913)	(727,757)	
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>6,104,592</b>	<b>8,658,692</b>	<b>4,018,214</b>	

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ:

# Инвескор ББСБ ХК II ангилалд шилжин орлоо

## ТОП-20 индекс-д багтлаа.



"Ковид-19 цар тахлын үед Монголын Хөрөнгийн бирж дээрх хувьцааны ханш буурсан хэдий ч "Инвескор ББСБ" ХК-ийн эхний хагас жилийн хувьцааны ханшыг 2020 оны эхэнтэй харьцуулахад **14.3** хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Энэ нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагч нар манай хувьцаанд итгэх итгэл нь өндөр байгааг харуулж байна.

**2'514 | ↑14.3%**

Хаалтын ханш /төгрөг/ 2020.01.01 - 06.30

**259,246**

Нийт арилжаалагдсан ширхэг

**666'313'763**

Нийт арилжаалагдсан дүн


**180'323'985'852**

Зах зээлийн үнэлгээ

**5'417'185**

Өдрийн дундаж арилжаа 2020.06.30

Биржийн 2020 оны 2 дугаар улирлын нийт арилжаанд эзлэх хувь



Инвескор /4%/  
Ард кредит /2%/  
Мандал даатгал /2%/  
Агу /7%/  
Монос хүнс /1%/  
Бусад /84%/



**InvesCore**  
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА